ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
8200 Говь-Алтай аймаг,
Баянжаргалан сум, Бэмбэгийн бөг,
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2016 07 22 № 167
гаргасан өдөр дугаар

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
О.АМГАЛАНБААТАР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төсвийн тухай хуулийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор мөн хуулийн 15.2 дахь заалтын бүрэн эрхийн хүрээнд Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн Захирагчийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, төсвийн гүйцэтгэл болон холбогдох бусад тайлан, илчлэл тодруулгад аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдэгдэл

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн Захирагч нь тайлант хугацаны санхүүгийн нэгтгэсэн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын батлосан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн Захирагчийн нэгтгэсэн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

ҮАГ-ын харьяа Говь-Алтай аймгийн Аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын батлосан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэл эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаардаг.

Аудитаар Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн Захирагчийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хүүль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцоолуг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Санхүүгийн тайлангийн зөрчилтэй илэрхийлсэн эсвэл орхигдуулсан мэдээллийн санхүүгийн тайлангийн хэрэглэгч нарын шийдвэрт нөлөөлөх материаллаг чанарын түвшинг 1,748,254.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Аудитаар:

- ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэж ноэж байгууллагуудын хувьд санхүүгийн тайлангийн аудитаар нийт 17,972,566.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнээс аудитын явцад 9,482,396.1 мянган төгрөгийн алдааг залруулсан ба 907,826.9

мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4,633,471.4 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх тухай дахахардсан тоогоор 95 албан тушаалтанд 323 заалт бүхий албан шаардлага, 414,422.1 мянган төгрөгийн зөрчилд 55 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага, 2,534,449.5 мянган төгрөгийн зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

- Аймгийн Орон нутгийн Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн нэгтгэсэн тайлангаар нийт 3,833,821.8 мянган төгрөгийн зөрчил илэрч, 286,607.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3,547,214.8 мянган төгрөгийн зөрчил арилгуулах, 12 хүнд хариуцлага тооцох албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.

Аудитаар нийт 9,789,542.2 мянган төгрөгийн зөрчилд илэрсэн нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал, тоцлуулга ба тодруулга гэсэн бүрэлдэхүүнийг хангахгүй байна.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн Захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын батлосан заавар, журмуудын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР